



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.51 дэх заалтад “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв гэж Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтад “төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө” гэж тус тус заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтыг хангах хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын төсвийг нэг худалдан авагчийн зарчмаар гүйцэтгэлд суурилсан хэлбэрээр 2021 оноос эхлэн санхүүжүүлж байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2024 онд нэмэгдэхтэй холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан улсын төсвөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэл болон тусламж үйлчилгээний зардал нэмэгдэхээр байна. Түүнчлэн төрийн албан хаагчдын цалин хөлс болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ, аж ахуй нэгж, байгууллагад ажиллагсдын дундаж цалин хөлсний өөрчлөлттэй уялдуулан эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Эрүүл мэндийн сангаас зарцуулах тусламж үйлчилгээний санхүүжилтийг анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бүс нутгийн онцлогийг харгалзсан ялгаатай байдлаар сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгүүдэд олгох, нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарахад чиглүүллээ. Мөн эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн өсөлтийг харгалзан эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний өртөг, тарифыг өсгөх шаардлага бий болж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн эрх, хэмжээ, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 2024 оны төсвийн жилд эрүүл мэндийн даатгалын сан бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт биелж, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлж, анхан шатанд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд

шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

--- оОо ---